



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБА

2019 оны 08 дугаар сарын 20

НИЙТИЙН ТЭЭВРИЙН ЗОРИУЛАЛТЫН ЗОГСООЛ /ЧД, 6, 7, 8, ДУГААР ХОРОО/ АЖЛЫН ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалт Нийтийн тээврийн зориулалтын зогсоол /ЧД, 6, 7, 8
гэрээний нэр: дугаар хороо/ ажил

Тендер шалгаруулалт ЧДХААА А19/43
гэрээний дугаар:

УЛААНБААТАР ХОТ

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо : 2019 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **Нийтийн тээврийн зориулалтын зогсоол /ЧД, 6, 7, 8 дугаар хороо/ ажил**

Тендер шалгаруулалтын дугаар: **ЧДХААА А19/43**

Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогдоос “**Нийтийн тээврийн зориулалтын зогсоол /ЧД, 6, 7, 8 дугаар хороо/ ажил**”-ыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендерийн материалыг цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50 000 /тавин мянга/ төгрөгийг www.tender.gov.mn-ээр банкны меркантын системийг ашиглан төлнө.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жил /2017, 2018/-ийн жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг нотариатаар баталгаажуулж ирүүлнэ.**
2. Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жил /2017, 2018/-ийн дундаж нь 35 000 000 /гучин таван сая/ төгрөгөөс багагүй байна.**
3. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн дүн: **15 000 000 /арван таван сая/ төгрөгөөс багагүй байна.**
4. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жил /2017, 2018/**
5. Шаардлагатай тусгай зөвшөөрөл: **Хуучин. 2.1.1. Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилтын тусгай зөвшөөрөл Эсхүл БА-8.1 Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интеръер, орчны тохижилтын ажлын тусгай зөвшөөрөлтэй байна.**

Тендерийн материалыг 2019 оны 09 дүгээр сарын 18 өдрийн 10 цаг 00 минутаас өмнө цахим системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр Худалдан авах ажиллагааны албаны 5 дугаар давхар, 511 тоот өрөөнд 2019 оны 09 дүгээр сарын 18 өдрийн 10 цаг 15 минутад нээнэ.

Дотоодын давуу эрхийн зэрүү: Тооцохгүй.

Гадаадын этгээд: Оролцох эрхгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, IV хороо, Ж.Самбуунийн гудамж-16, Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудын II байр, Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр, Худалдан авах ажиллагааны алба, 511 тоот өрөө Утас: 70110769

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бэглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдэж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн телөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг запруулах**
 - 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар запруулна:
 - (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;

- (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үргүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нэхцэл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нэхцэлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-НЫХОЛБОГОХЗААЛТ	А.Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<p>Захиалагч: Нийслэлийн Засаг даргын Тамгын газар</p> <p>Санхүүжилтийн эх үүсвэр нь: Нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сан Батлагдсан төсөвт өртөг: 50 000 000 /тавин сая/ төгрөг</p>
ТОӨЗ 1.1 (а)	Үнийн санал /маягтын дагуу ирүүлнэ /
ТОӨЗ 1.1 (б)	Хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбарыг нотариатаар баталгаажуулж ирүүлнэ.
ТОӨЗ 1.1 (в)	<p>Үг гэрээг гүйцэтгэхэд тусгай зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай эсэх: "Тийм" Шаардлагатай тусгай зөвшөөрөл: Барилга угсралтын ажил гүйцэтгэх байгууллага нь дараах тусгай зөвшөөрөлтэй байна.</p> <ul style="list-style-type: none"> - Хуучин. 2.1.1. Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилтын тусгай зөвшөөрөл Эсхүл - БА-8.1 Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажлын тусгай зөвшөөрөлтэй байна. - Түншлэл болон туслан гүйцэтгэгчтэй оролцох тохиолдолд түнлэгч, туслан гүйцэтгэгч нь тус бүрдээ тендерийн баримт бичигт заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаж байх ёстой. - Тусгай зөвшөөрлийн эхээс хийсэн хуулбар, түүний гэрээ, хавсралтыг нотариатаар баталгаажуулж ирүүлнэ. /Тендер зарлагдсан өдрөөс хойш нотариатаар баталгаажуулсан байна./ <p>Тусгай зөвшөөрлийн хугацаа нь тендерийн хүчинтэй хугацаа болон гэрээний хугацаанд хүчин төгөлдөр байна. Хэрэв тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан бол Төрийн эрх бүхий байгууллагаас хугацааг сунгасан талаарх тодорхойлолтыг ирүүлнэ. Тусгай зөвшөөрлийг сунгах эсэхийг судалж байна гэх утга бүхий тодорхойлолтыг хүчингүйд тооцно.</p>
ТОӨЗ 1.1 (г)	Тендерт оролцогч хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 -14.7-д дурдсан нөхцөл үүссэн тухай мэдээгдлийг захиалагчид бичгээр гаргаж ирүүлнэ.
ТОӨЗ 1.1 (д)	Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил /2017, 2018/-ийн жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг нотариатаар баталгаажуулж ирүүлнэ. Харин /2017, 2018/-ийн жилийн эцсийн санхүүгийн тайлан нь Сангиин яамны И баланс цахим системд шивээгдэж баталгаажсан байна. /Санхүүгийн тайлан нь Сангиин яамны и баланс цахим системд шивээгдэж баталгаажаагүй бол тендерээс татгалзах үндэслэл болно./
ТОӨЗ 1.1 (е)	Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил /2017, 2018/-ийн дундаж нь 35 000 000 /гучин таван сая/ төгрөгөөс багагүй байна.

ТӨӨЗ 1.1 (ё)	<p>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн дүн: 15 000 000 /арван таван сая/ төгрөгөөс багагүй байна.</p> <p>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр тодорхойлно.</p> <p>Боломжит санхүүгийн бусад эх үүсвэр:</p> <ul style="list-style-type: none"> - Зээл авах баталгаажсан эрх буюу харилцагч банкны уг тендерт шаардсан хэмжээнд хүрэлцэхүйц зээл олгох боломжтой талаар тодорхойлолт ирүүлэх. /Банк бус санхүүгийн байгууллагын тодорхойполтыг хүчингүйд тооцно./ - Харилцагч банкин дахь дансны үлдэгдлийг харуулсан хуулга - Тухайн байгууллагын нэр дээрхи үл хөдлөх хөрөнгийг барьцаалан зээл авах тухай санал оруулж байгаа бол үл хөдлөх хөрөнгийн зээлийн барьцаанд тавиагүй талаар үл хөдлөх хөрөнгийн мэргэшсэн үнэлгээчнээр хийлгэсэн үнэлгээний сертификат зэргийг ирүүлнэ. - 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаас: Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг Санрийн сайдын 2015 оны 343 дугаар тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн загвар”-ын 3.2.2 /е/-д “түргэн хөрвөх чадвартай хөрөнгө =Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө+ санхүүгийн хөрөнгө+ Дансны авлага гэсэн үзүүлэлтүүдээр дүгнэнэ” гэж заасны дагуу тодорхойлно. 															
ТӨӨЗ 1.1 (ж)	<p>Хийж гүйцэтгэсэн ажлын нийт мөнгөн дүнг жил жилээр харуулсан жагсаалт ирүүлэх шаардлагатай жилийн тоо:Сүүлийн 2 жил буюу /2017, 2018/</p> <p>Хийж гүйцэтгэсэн ажлын тайланг дараах хүснэгтээр ирүүлнэ.</p> <table border="1" data-bbox="461 1282 1471 1484"> <thead> <tr> <th>№</th><th>Гэрээний нэр</th><th>Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас/факс</th><th>Төсөөтөртөг</th><th>Дууссан, эсхүл дусах хугацаа</th></tr> </thead> <tbody> <tr> <td>1</td><td></td><td></td><td></td><td></td></tr> </tbody> </table>	№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас/факс	Төсөөтөртөг	Дууссан, эсхүл дусах хугацаа	1									
№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас/факс	Төсөөтөртөг	Дууссан, эсхүл дусах хугацаа												
1																
ТӨӨЗ 1.1 (з)	<p>Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил /2017, 2018/</p> <ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн 2 жилд хийж гүйцэтгэсэн ижил төстэй тохижилтын ажлын жагсаалтыг он тус бүрээр гаргаж ирүүлнэ. 2. Гэрээ болон ажил хүлээлгэж өгсөн улсын комиссын актын хуулбарыг ирүүлнэ. 3. Хийж гүйцэтгэсэн ажлын фото зургийг өнгөтөөр гаргаж ирүүлнэ. <table border="1" data-bbox="461 1731 1471 2001"> <thead> <tr> <th>№</th><th>Гэрээний нэр</th><th>Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас/факс</th><th>Төсөөтөртөг</th><th>Дууссан, эсхүл дусах хугацаа</th></tr> </thead> <tbody> <tr> <td>1</td><td></td><td></td><td></td><td></td></tr> <tr> <td></td><td>ДҮН</td><td></td><td></td><td></td></tr> </tbody> </table>	№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас/факс	Төсөөтөртөг	Дууссан, эсхүл дусах хугацаа	1						ДҮН			
№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас/факс	Төсөөтөртөг	Дууссан, эсхүл дусах хугацаа												
1																
	ДҮН															

ТОӨЗ 1.1 (и)	<p>Тендерт оролцогч компани гэрээг хэрэгжүүлэх чадвартайг нотлохын тулд дараах нэмэлт нотлох баримтыг тендерт ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Харьяа Татварын хэлтсийн тодорхойлолт /цахим/ 2. Харьяа Нийгмийн даатгалын хэлтсийн тодорхойлолт /шиштгэл хураамжаа төлсөн эсэх талаар/ 3. Харилцагч банкны тодорхойлолт /хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байна./ 4. Монгол Улсын Шүүхийн өрөнхий зөвлөлийн ажлын албаны /төрөлжсөн архив/ тодорхойлолт 5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтуудыг тус тус эх хувиар ирүүлнэ. <i>/Дээрх тодорхойлолтуудыг тендер зарлагдсан өдрөөс хойш авсан байна. Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлсөн эсэхийг тендер нээсэн өдрөөр тооцно./</i> 6. Тендерт оролцогч нь харьяа татвар, нийгмийн даатгал, харилцагч банк, шүүхийн байгуулагаас тендертэй холбоотой газруудаас лавлагаа авахад татгалзах зүйлгүй тухай мэдэгдэл ирүүлнэ. 7. Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг нотариатоор баталгаажуулж, итгэмжлэгдсэн этгээдийн иргэний үнэмлэхний хуулбарын хамт ирүүлнэ. <i>Тайлбар: /Компаний захирал өөрөө өөрийгөө итгэмжлэх тохиолдолд нотариатаар баталгаажуулах шаардлагагүй./</i> 8. Тендерийн баримт бичгийн Гэрээний өрөнхий болон Тусгай нөхцлийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ. 9. Тендерт оролцогчийн ирүүлсэн үнийн санал, тендерийн үр дүнг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл ирүүлнэ. 																								
ТОӨЗ 1.1 (к)	<p>Гэрээг хэрэгжүүлэх удирдах болон инжекжер техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл:</p> <table border="1" data-bbox="463 1260 1472 1769"> <thead> <tr> <th>Албан тушаал</th><th>Хүний тоо</th><th>Мэргэжил</th><th>Ажлын туршлага /жилээр/</th><th>Шаардлагатай баримт бичиг</th><th>Үндсэн ажилтан эсэх</th></tr> </thead> <tbody> <tr> <td>Ерөнхий инженер</td><td>1</td><td>Иргэний ба үйлдвэрийн барилгын инженер</td><td>Мэргэжлээрээ 5 буюу түүнээс дээш жил</td><td>Диплом</td><td>Үндсэн</td></tr> <tr> <td>ХАБ-ажилтан</td><td>1</td><td>Мэргэжил харгалзахгүй</td><td>ХАБЭА-н инженерээр 2 буюу түүнээс дээш жил</td><td>Диплом, ХАБЭА гэрчилгээ, сертификат</td><td>Үндсэн</td></tr> <tr> <td>Туслах ажилчид</td><td>3</td><td>Мэргэжил харгалзахгүй</td><td>-</td><td>-</td><td>Гэрээт</td></tr> </tbody> </table> <ul style="list-style-type: none"> • Ерөнхий инженер, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан, нь тухайн аж ахуйн нэгжид ажилладаг үндсэн ажилтан байна. • Үндсэн ажилчдын сургууль төгссөн мэргэжлийн диплом, мэргэжлийн үнэмлэхний эхээс хийсэн хуулбарыг нотариатаар баталгаажуулж иргэний үнэмлэхний хуулбарын хамт ирүүлнэ. 	Албан тушаал	Хүний тоо	Мэргэжил	Ажлын туршлага /жилээр/	Шаардлагатай баримт бичиг	Үндсэн ажилтан эсэх	Ерөнхий инженер	1	Иргэний ба үйлдвэрийн барилгын инженер	Мэргэжлээрээ 5 буюу түүнээс дээш жил	Диплом	Үндсэн	ХАБ-ажилтан	1	Мэргэжил харгалзахгүй	ХАБЭА-н инженерээр 2 буюу түүнээс дээш жил	Диплом, ХАБЭА гэрчилгээ, сертификат	Үндсэн	Туслах ажилчид	3	Мэргэжил харгалзахгүй	-	-	Гэрээт
Албан тушаал	Хүний тоо	Мэргэжил	Ажлын туршлага /жилээр/	Шаардлагатай баримт бичиг	Үндсэн ажилтан эсэх																				
Ерөнхий инженер	1	Иргэний ба үйлдвэрийн барилгын инженер	Мэргэжлээрээ 5 буюу түүнээс дээш жил	Диплом	Үндсэн																				
ХАБ-ажилтан	1	Мэргэжил харгалзахгүй	ХАБЭА-н инженерээр 2 буюу түүнээс дээш жил	Диплом, ХАБЭА гэрчилгээ, сертификат	Үндсэн																				
Туслах ажилчид	3	Мэргэжил харгалзахгүй	-	-	Гэрээт																				

	<ul style="list-style-type: none"> Үндсэн ажилтан тус бүрээр нийгмийн даатгалын дэвтрийн нүүр болон даатгуулагчийн ажил, албан тушаалын өөрчлөлтийн тэмдэглэлийн хуулбарыг Төрийн үйлчилгээний цахим машин буюу ТҮЦ машинаас авсан нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт /тухайн ажилтны ажлын туршлагад заасан жилүүд/-ы хамт ирүүлнэ./ Ундсэн ажилтны ажлын туршлага, ажилласан жилийг нийгмийн даатгалын дэвтэр, ТҮЦ машины тодорхойлолтоор тус тус нотлоно./ Барилгын туслах ажилчдын жагсаалт, хөлсөөр буюу түр ажлуулах гэрээг иргэний үнэмлэхний хуулбарын хамт ирүүлнэ. <p>Тайлбар: Шаардсан баримт бичгүүд мэргэжлийн диплом, иргэний үнэмлэх, мэргэжлийн үнэмлэх, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар тус бүрийг тод гаргацтай ирүүлнэ. Хэрэв баримт бичгийн стандартын шаардлага хангахгүй, бүдэг, уншигдах боломжгүй материал ирүүлвэл тендерээс татгалзах үндэслэл болно.</p>																															
ТОӨЗ 1.1 (л)	Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмууд Үүнд:																															
A. МАШИН МЕХАНИЗМ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ																																
<table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th>№</th><th>Машин механизм, тоног төхөөрөмж</th><th>Тоо ширхэг</th><th>Хүчин чадал</th><th>Аж ахуйн нэгжийн эзэмшил</th><th>Фото зураг</th></tr> </thead> <tbody> <tr> <td>1</td><td>Автокран буюу өргөгч машин</td><td>1</td><td>5 тн доошгүй</td><td>Компанийн эзэмшлийн эсхүл түрээсийн байж болно.</td><td>Зураг ирүүлнэ.</td></tr> <tr> <td>2</td><td>Ачааны машин</td><td>1</td><td>1 тн дээш</td><td>Компанийн эзэмшлийн</td><td>Зураг ирүүлнэ.</td></tr> </tbody> </table>						№	Машин механизм, тоног төхөөрөмж	Тоо ширхэг	Хүчин чадал	Аж ахуйн нэгжийн эзэмшил	Фото зураг	1	Автокран буюу өргөгч машин	1	5 тн доошгүй	Компанийн эзэмшлийн эсхүл түрээсийн байж болно.	Зураг ирүүлнэ.	2	Ачааны машин	1	1 тн дээш	Компанийн эзэмшлийн	Зураг ирүүлнэ.									
№	Машин механизм, тоног төхөөрөмж	Тоо ширхэг	Хүчин чадал	Аж ахуйн нэгжийн эзэмшил	Фото зураг																											
1	Автокран буюу өргөгч машин	1	5 тн доошгүй	Компанийн эзэмшлийн эсхүл түрээсийн байж болно.	Зураг ирүүлнэ.																											
2	Ачааны машин	1	1 тн дээш	Компанийн эзэмшлийн	Зураг ирүүлнэ.																											
Б.ШААРДЛАГАТАЙ БАГАЖ ХЭРЭГСЭЛ																																
<table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th>№</th><th>Хяналт, шалгалтын багаж хэрэгсэл</th><th>Тоо ширхэг</th><th>Өөрийн</th><th>Фото зураг</th></tr> </thead> <tbody> <tr> <td>1</td><td>Угсралтын агергат</td><td>1</td><td>Өөрийн</td><td>Зураг ирүүлнэ.</td></tr> <tr> <td>2</td><td>Хийн гагнуурын аппарат</td><td>1</td><td>Өөрийн</td><td>Зураг ирүүлнэ.</td></tr> <tr> <td>3</td><td>Цахилгаан эргүүлэг</td><td>1</td><td>Өөрийн</td><td>Зураг ирүүлнэ.</td></tr> <tr> <td>4</td><td>Цахилгаан багаж хэрэгсэл</td><td>Иж бүрдэл</td><td>Өөрийн</td><td>Зураг ирүүлнэ.</td></tr> </tbody> </table>						№	Хяналт, шалгалтын багаж хэрэгсэл	Тоо ширхэг	Өөрийн	Фото зураг	1	Угсралтын агергат	1	Өөрийн	Зураг ирүүлнэ.	2	Хийн гагнуурын аппарат	1	Өөрийн	Зураг ирүүлнэ.	3	Цахилгаан эргүүлэг	1	Өөрийн	Зураг ирүүлнэ.	4	Цахилгаан багаж хэрэгсэл	Иж бүрдэл	Өөрийн	Зураг ирүүлнэ.		
№	Хяналт, шалгалтын багаж хэрэгсэл	Тоо ширхэг	Өөрийн	Фото зураг																												
1	Угсралтын агергат	1	Өөрийн	Зураг ирүүлнэ.																												
2	Хийн гагнуурын аппарат	1	Өөрийн	Зураг ирүүлнэ.																												
3	Цахилгаан эргүүлэг	1	Өөрийн	Зураг ирүүлнэ.																												
4	Цахилгаан багаж хэрэгсэл	Иж бүрдэл	Өөрийн	Зураг ирүүлнэ.																												
Г.ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛЛЫН БАГАЖ ХЭРЭГСЭЛ																																
<table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th>№</th><th>Хөдөлмөр хамгаалаллын багаж хэрэгсэл</th><th>Тоо ширхэг</th><th>Хүчин чадал</th><th>Өөрийн</th><th>Фото зураг</th></tr> </thead> <tbody> <tr> <td>1</td><td>Ажлын бээлий</td><td>-</td><td rowspan="4">Иж бүрдэл</td><td>Өөрийн</td><td>Зураг ирүүлнэ.</td></tr> <tr> <td>2</td><td>Хамгаалах бүс</td><td>-</td><td>Өөрийн</td><td>Зураг ирүүлнэ.</td></tr> <tr> <td>3</td><td>Малгай /каск/</td><td>-</td><td>Өөрийн</td><td>Зураг ирүүлнэ.</td></tr> <tr> <td>4</td><td>Ажлын хувцас</td><td>-</td><td>Өөрийн</td><td>Зураг ирүүлнэ.</td></tr> </tbody> </table>						№	Хөдөлмөр хамгаалаллын багаж хэрэгсэл	Тоо ширхэг	Хүчин чадал	Өөрийн	Фото зураг	1	Ажлын бээлий	-	Иж бүрдэл	Өөрийн	Зураг ирүүлнэ.	2	Хамгаалах бүс	-	Өөрийн	Зураг ирүүлнэ.	3	Малгай /каск/	-	Өөрийн	Зураг ирүүлнэ.	4	Ажлын хувцас	-	Өөрийн	Зураг ирүүлнэ.
№	Хөдөлмөр хамгаалаллын багаж хэрэгсэл	Тоо ширхэг	Хүчин чадал	Өөрийн	Фото зураг																											
1	Ажлын бээлий	-	Иж бүрдэл	Өөрийн	Зураг ирүүлнэ.																											
2	Хамгаалах бүс	-		Өөрийн	Зураг ирүүлнэ.																											
3	Малгай /каск/	-		Өөрийн	Зураг ирүүлнэ.																											
4	Ажлын хувцас	-		Өөрийн	Зураг ирүүлнэ.																											

	<p>1. Автокран буюу өргөгч машин (5 тонн-оос доошгүй) -1, Ачааны машин-1 тус бүрийн авто тээврийн хэрэгслийн гэрчилгээ, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар төлөгчийн гэрчилгээг эхээс хийсэн хуулбарыг тус тус нотариатаар баталгаажуулж ирүүлнэ.</p> <p>2. Автокран буюу өргөгч машин-1 түрээслэх бол түрээсийн гэрээний хуулбарыг нотариатаар баталгаажуулж нэмэлтээр ирүүлнэ.</p> <p>3. Бусад шаардлагатай тоног төхөөрөмж болон Хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслийн фото зургийг хавсаргаж ирүүлнэ.</p> <p>Жич:Компанийн эзэмшлийн гэж заасан тохиолдолд машин механизмыг түрээслэх гэсэн ойлголт байхгүй болно.</p>
ТОӨЗ 1.1 (м)	<p>Тендерт оролцогч туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж болох хувь хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн 10 хүртэл хувийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж болно. Үүнээс дээш хувийг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх бол түншлэлийн гэрээ байгуулж тендерийн хамт ирүүлэх ба ТОӨЗ-нд дурдсан бусад шалгуурыг хангасан байх шаардлагатай.</p> <p>Түншлэлийн гишүүд дараах нэмэлт шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Иргэний хуульд заасан хамтран ажиллах гэрээний шаардлага хангасан түншлэлийн гэрээг ирүүлнэ. /Гэрээнд түншлэлийн гишүүн бүрийн хүлээх хариуцлага, хийх ажил болон ажлын үнэлгээг тооцож ирүүлнэ. Түншлэгч байгууллагаас аливаа үүрэг хүлээх, зааварчилгаа хүлээн авах, төлбөр тооцоо хийхэд тэдгээрийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүн томилон нийт гэрээний гүйцэтгэл, түүний дотор төлбөрийг зөвхөн төлөөлөх эрх бүхий гишүүнтэй тооцохыг хамтран ажиллах гэрээгээр зохицуулсан байна./ - Мөн Тендерийн баримт бичигт заасан мэдээллийг түншлэлийн гишүүн тус бүрдээ гаргаж, тендерийн хамт ирүүлнэ. - Түншлэлээр орж байгаа бол түншлэлийн гишүүн тус бүр ТОӨЗ-ийн 5.2-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийн доод тал нь 25 хувийг, төлөөлөх эрх бүхий гишүүн доод тал нь 40 хувийг хангасан байна. - Түншлэлийн төлөөлөх эрхгүй гишүүн Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийн ТОӨЗ “4.2.2, 4.2.4, 4.4а, 4.4в, 5.2в, 5.2д”-д заасан нотлох баримтыг ирүүлнэ.
Б. Тендерийн баримт бичиг	
ТОӨЗ 2.1	<p>Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: Чингэлтэй дүүрэг, IV хороо Ж.Самбуугийн гудамж-16, Нийслэлийн Нутгийн Захиргааны байгууллагуудын II байр, Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр 511 тоот, Худалдан авах ажиллагааны алба Утас: 70110769</p> <p>Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүснэгтийг хүлээн авах эцсийн хугацаа нь тендер хүлээн авах эцсийн өдрөөс ажлын 5 хоногоос багагүй байна.</p>
ТОӨЗ 2.1 а	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалтыг зохион байгуулах эсэх: “Үгүй”
В. Тендер бэлтгэх	
ТОӨЗ 2.2	Энэхүү тендерт гадаадын этгээд оролцох эрхгүй бөгөөд тендерийн баримт бичиг Монгол хэл дээр байна.
ТОӨЗ 2.2 а	<p>Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:</p> <ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын тухай танилцуулга ирүүлнэ.

	<p>2. Нийгмийн даатгалын НД07, НД08 маягтын дагуу лавлагаа тайлан /2019 оны III, IV, V, VI, VII сар/-ыг ирүүлнэ.</p> <p>3. Ажил гүйцэтгэх нарийвчилсан хугацааны график ирүүлнэ. /Компанийн удирдлагагарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулсан байна/</p> <p>4. Зураг, ажлын тоо хэмжээний дагуу тооцсон төсөвтэй, эрх бүхий төсөвчнээр баталгаажуулсан байна. /Төсвийг Барилга хот байгуулалтын Сайдын 2015 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 185-р тоот тушаалаар батлагдсан нэмэлт өөрчлөлтийг тооцсон төсөвтэй байна. Монгол Улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсөв зохиох программаар гүйцэтгэнэ/ Зохиогчийн хяналтын зардлыг зохих норм нормативийн дагуу төсөвт тусгаж ирүүлэх бөгөөд ажлын тоо хэмжээ зураг зөрвөл зургийн тоо хэмжээг баримтлана.</p> <p>5. Нийтийн тээврийн зориулалтын зогсоолын чанарын баталгаат хугацаа 3 жил байна. Албан бичгийг компанийн удирдлага гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулсан байна.</p> <p>6. Нийтийн тээврийн зориулалтын зогсоолын ажилд ашиглах материалын чанар стандартын шаардлагад нийцсэн гэсэн эрх бүхий байгууллагын тодорхойлолт нотлох баримт ирүүлнэ.</p> <p>7. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэд багтаан Нийтийн тээврийн зориулалтын зогсоолын ажлыг, ажлын зураг, техникийн тодорхойлолтын дагуу чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэн дуусгаж, 2019 онд хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.</p> <p>8. Нийтийн тээврийн зориулалтын зогсоолын ажлын чанаргүй, гүйцэтгэлээс үссэн эвдрэл, гэмтлийг баталгаат засварын хугацаанд өөрийн зардлаар шуурхай засварлах ажлыг хийж гүйцэтгэх тухай албан бичиг ирүүлнэ.</p> <p>Тендерт оролцогч тал: Тендерийн материалыг ТОӨЗ -д заасан /дээрх/ дарааллын дагуу эмхэтгэж, худас бүрийг дугаарлаж гарын үсэг зурж баталгаажуулан, цахим хэлбэр Adobe (pdf) форматаар ирүүлнэ. Ирүүлэхдээ харагдах хэлбэр нь уншигдахаар тод гаргацтай байна. (Үнэлгээ хийхэд уншигдах боломжгүй бүдэг, дутуу, засвартай, тендерийн материалыг ирүүлсэн тохиодолд тухайн тендерээс татгалзах үндэслэл болгоно.)</p>
ТОӨЗ 2.2 в	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад тохируулахгүй тогтмол байна .
ТОӨЗ 2.2 г	Хувилбарт тендер ирүүлэхийг: “ Зөвшөөрөхгүй ”
ТОӨЗ 2.2 д	Тендерийн валют: Төгрөг байна .
ТОӨЗ 2.2 е	Тендер нээнээс хойш 30 хоногийн туршид хүчинтэй байна. Г. Тендер ирүүлэх
ТОӨЗ 3.1	<p>Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь:</p> <p>Цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар тоон гарын үсэг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцож хураамж 50,000 төгрөгийг www.tender.gov.mn –ээр банкны меркантийн системийг ашиглан төлнэ.</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) –ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p>
ТОӨЗ 3.1 а	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:

	<p>Огноо: 2019 оны 09 дүгээр сарын 18 өдөр Цаг: 10 цаг 00 минут</p> <p style="text-align: center;">Д. Тендерийг нээх, үнэлэх</p>
ТОӨЗ 3.1 б	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд:</p> <p>Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, IV хороо, Ж.Самбуунийн гудамж-16, Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудын II байр, Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр, Худалдан авах ажиллагааны алба, 511 тоот өрөө Утас: 70110769</p>
ТОӨЗ 3.1 в	<p>Тендерийн нээлт хийх огноо: 2019 оны 09 дүгээр сарын 18 өдөр Цаг: 10 цаг 15 минут</p>
ТОӨЗ 3.1 г	<p>Дотоодын давуу эрхийн зөрүү: Тооцохгүй</p>



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

4.1 Байршил: ЧД, 6,7,8 дугаар хороо

4.2 Ажлын цар хэмжээ: Нийтийн тээврийн зориулалтын зогсоол

Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөж буй хууль, тогтоомж, Барилгын норм ба дүрэм /БНБД/, стандарт холбогдох журам зааврын дагуу хийж гүйцэтгэнэ. Дээрхи ажлуудыг барилгын ажилд зохиогчийн хяналт хийх дүрэм БНБД 11-04-99, Зургийн ерөнхий инженер (ерөнхий архитектор) –ийн дүрэм БНБД 11-06-03 зэрэг холбогдох хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандартуудын дагуу хийж гүйцэтгэнэ. Ажлын зураг төслөөр сонгогдсон буюу түүнтэй дүйцэхүйц, тухайн орон нутгийн цаг уурын нөхцөлд тохирсон, олон улсын стандартын шаардлага хангасан материал, тоног төхөөрөмжийг сонгож авсан байна.

Барилга байгууламжийн ажлын зохион байгуулалт, түүнд тавигдах шаардлага

Барилгын ажил буюу гэрээнд тусгагдсан бүх ажлыг хийж гүйцэтгэхдээ Монгол улсад мөрдөж буй хууль, тогтоомж, болон хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дараах Барилгын норм ба дүрэм /БНБД/, стандарт холбогдох журам зааврын дагуу хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1. Барилга угсралтын ажилд мөрдөх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн заавар БД 12-03-04
2. Барилгын талбайн даамлын үлгэрчилсэн дүрэм УББ 12-204-01
3. Барилгын орчны тохижилтын ажил БНБД 3.01.06-90
4. Барилгын газар шороо ба буурь суурийн ажил БНБД 3.02.01-90
5. Модон бүтээц БНБД 54-02-05
6. Барилга засварын ажлын төсвийн суурь норм

Талбайн ажлыг хийж гүйцэтгэхдээ талбайн зохион байгуулалтын зураг хийж зургийн дагуу хашаа, түр байр, харуулын байр хувцас солих байр зэргийг байрлуулж, бусад ажилтай уялдуулан, тухайн байршилд ажил үйлчилгээ явуулж буй аж ахуйн нэгж байгууллагууд, амьдарч буй иргэдэд ямар нэгэн саад бэрхшээл гаргалгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэн ажиллана.

Ажлыг хийж гүйцэтгэж байх явцад материал эдлэлүүдээс дээж авч эрх бүхий сорил шинжэлгээний байгууллага /лаборатори/-р сорил шинжэлгээнд оруулж баталгаажуулна. Технологийн үе шат бүрд гүйцэтгэсэн ажлыг төслийн менежер, болон зураг тесөл зохиогч бөгөөд авторд үзүүлж байх ба техникийн шаардлага хангасан гэж үзвэл ил, далд ажлын акт дээр гарын үсэг зуруулж фото зургийн хамт баталгаажуулж дараагийн үе шатны ажлыг гүйцэтгэх байдлаар ажил эхлэх үеэс нь эхлэн ажлыг хийж дуусгах хүртэлх бүх технологийн үйл ажиллагаанд хяналт тавиulan ажиллана.

Ажил эхлэхээс өмнө ХАБЭА-н инженер Барилга угсралтын ажилд мөрдөх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн заавар БД 12-03-04 заасны дагуу үе шатны ажил бүр дээр аргачилсан заавирчилгаа өгч ажиллана.

Талбайд барилгын ажлын журналыг байнга бэлэн байлгаж, холбогдох хяналтын инженерүүдийн өгсөн шаардлага, дүгнэлтийг журналд бичиж хөтлөн захиалагчаар баталгаажуулна.

4.4 Захиалагчийн хяналтын ажил

Барилгын ажлын явцад гарах зураг төсөвтэй холбоотой асуудлыг газар дээр нь холбогдох хүмүүстэй хамтарч шийдвэрлүүлж байна.

Гүйцэтгэгч байгууллага нь заагдсан ажлын тоо хэмжээ, зургийн дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэх нөхцлийг бүрдүүлэн ажиллана.

Гүйцэтгэгч байгууллага

Ажил гүйцэтгэх явцдаа байнга фото зургаар баталгаажуулан далд ажлын акт үйлдэнэ. Ажлын явцад өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас эвдэрсэн байгууламжуудыг нөхөн сэргээн засварлаж хэвийн байдалд оруулна.

Ажил гүйцэтгэх явцад талбайд ажиллаж буй ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч, аюулгүй ажиллагааны нөхцлийг бүрэн хангаж ажиллана.

Байгалийн гэнэтийн гамшиг, гал түймэр, үер усны гамшигаас сэргийлэн даатгалд бүрэн хамрагдан аюулгүй байдлыг хангаж ажиллана.

Эдгээр арга хэмжээг авалгүй гэнэтийн гамшигт өртөх, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зөрчил гаргавал хор хохирлыг гүйцэтгэгч бүрэн хариуцна.

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

БАРИЛГЫН АЖЛЫН ЗУРГИЙГ ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ СИСТЕМ tender.gov.mn ЦАХИМ СИСТЕМИЙН ТЭЗҮ ХЭСЭГТ БАЙРЛУУЛАВ.

a. Ажлын тоо хэмжээг үнэлэх санамж:

1. Ажлын тоо хэмжээг үнэлэхдээ үнэлэгдэх ажлын тоо хэмжээний жагсаалт болон тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа, гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, ажлын зураг зэргийг бодит байдалтай холбож нягтлан үзэхийг анхааруулж байна.
2. Гэрээнд тусгайлан заагаагүй нөхцөлд тендерт ирүүлсэн үнийн саналд ажлын тоо хэмжээнд тохирсон үнэд барилгын ажлыг явуулахад шаардагдах тоног төхөөрөмж, ажиллас хүчний хөлс, материал, түүний элэгдэл засвар, нийгмийн ба эрүүл мэнд, үйлдвэрлэл, ханган нийлүүлэлтийн зардлууд, ашиг бүх төрлийн татвар хураамж, /НӨАТ,гаалийн татвар г.м/ банкны үйлчилгээний шимтгэл,үйлдвэрлэлийн ба ахуйн зориулалттай бүх зардлууд /сорилт, туршилт, баталгаажуулалт, гадаад ажилтнуудын ирэх,буцах болон тэдгээрийн Монгол улсад ажиллуулахтай холбогдсон зардал, ажилчдын байрлах байр, ажилчдыг зөөх унаа г.м/ мөн нэмэгдэл дайвар ба захиалагчийн техник хяналтын зардал болон гэрээний үүрэгт хамруулах ёстой бусад үүрэг хариуцлагыг тооцож шингээсэн байна.
3. Ажлын тоо хэмжээг үнэлэхдээ *Барилгын төсөв зохиох дүрэм* БНБД 81-94-12-ын шинэчлэгдсэн программын дагуу үнэлж, үнэлгээнд техник хяналт, магадлашгүй ажил, нэмэгдсэн өргтийн албан татвар, зураг төсвийн үнэ 220 000 /Хоёр зуун хорин мянга/

төгрөг, нормчлолын санг тооцож оруулна. Ажлын тоо хэмжээг тооцсон төсвийн дүн нь Тендерт ирүүлж буй үнийн саналтай ижил байх ба дээрх зардлуудаас төсөвт өртгийн товчоонд тооцогүй үлдээсэн тохиолдолд Тендерт оролцогчийн ирүүлж буй үнийн санал дээр нэмж тооцож бусад оролцогч нарын үнийн саналтай харьцуулан Тендерийн үнэлгээнд оруулах болно.

4. Ажлын тоо хэмжээнд заагдсан ажлыг үнэлэхдээ ажил гүйцэтгэх технологийн дагуу ажил, ажилбаруудаар задалж нэгжийн норм үнэлгээгээр үнэлэхийг анхааруулж байна. Гэхдээ нэгжийн норм үнэлгээ дотроо тусгагдсан ажилбаруудыг дахин давтан үнэлсэн байж болохгүй.

Талбайгаас гарсан хог хаягдалыг тухайн дүүргийн зөвшөөрөгдсөн хогийн цэгт тээвэрлэж зайлзулахаар зардлыг тооцож ирүүлнэ.

5. Тухайн ажилд шаардлагатай материалын нийлүүлэлтийн график, захиалгын гэрээний талаарх мэдээллийг ирүүлсэн байх.

БУУДЛЫН САРАВЧНЫ АЖИЛ

№	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Суурин нүх гараар ухах	м3	0,3
2	Бетон суурь цутгах	м3	0,3
3	Төмөр каркас хийж угсрах	тн	0,6
4	Төмөр хийцийн бэлдэц бэлтгэх	тн	0,6
5	Төмөр хийц төмрийн будгаар будах	тн	0,6
6	Лист	м2	8
7	Лист төмрөөр дээвэр хийх	м2	12
8	Хатаасан шилэн хаалт суулгах	м2	20
9	Төмөр рам хийж угсрах	тн	0,0385
10	Хогийн сав суурилуулах	ш	1
11	Сандалны хийц угсрах /квадрат төмөр/	тн	0,05
12	Төмөр хийцийн бэлдэц бэлтгэх	тн	0,05
13	Төмөр хийц төмрийн будгаар будах	тн	0,05
14	Төмөр хашлаганы нүх гараар ухах	м3	0,36
15	Төмөр хашлаганы бетон суурь цутгах	м3	0,36
16	Ган хоолойгоор хашлага хийц угсрах ф80, 50мм	тн	0,202
17	Төмөр хийц төмрийн будгаар будах	тн	0,202
18	Лед гэрэлтуулэгч суурилуулах	ш	2
19	Туузан гэрэл суурилуулах	м	26
20	Кабелийн шуудууны нүх гараар ухах	м3	7
21	Элсэн дэвсгэр эхний кабельд хийх	м	20
22	Кабелийг шуудуунд сунгах АВВБ	м	30
23	Шуудуу хүнхээл нүхийг 1-р зэргийн хөрсөөр эргүүлж булах	м3	5,8

Жич: Буудлын саравчны тоо хэмжээ 1 ширхэгийн ажлын тоо хэмжээ өгөгдсөн бөгөөд нийт 3 ширхэгийг хийх тул аж ахуйн нэгжүүд нэмж тооцож ирүүлнэ үү.

БАРИЛГЫН АЖЛЫН ЗУРГИЙГ ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ СИСТЕМ tender.gov.mn ЦАХИМ СИСТЕМИЙН ТЭЗҮ ХЭСЭГТ БАЙРЛУУЛАВ.

Зургаа. ЖИШИГ МАЯГТ

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

Чингэлтэй дүүргийн Засаг дарга Ж. Эрдэнэбат танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Долоо. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх	1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.
2. Төслийн менежерийн шийдвэр	2.1. Гэрээнд тусгайллан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.
3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх	3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.
4. Аюулгүй байдал	4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана. 4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.
5. Зааварчилгаа	5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй
6. Маргааныг шийдвэрлэх	6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.
Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ	
7. Ажлын хөтөлбөр	7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна. 7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.
8. Зөрчил, гологдол илрүүлэх	8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. 8.2. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
9. Зөрчил, гологдол арилгах	9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана. 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.
10. Зөрчил, гологдол арилгахгүй байх	10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

B. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Ye шатны ажлын хуваарь** 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Ye шатны ажлын хуваарын тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Ye шатны ажлын хуваарийг өөрчлөх** 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарын нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги** 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги төлнэ. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс сутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.
- Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ**
- 14. Ажил дуусгах** 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлцуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах** 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо** 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусгахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай запруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага** 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

	17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстай төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
18. Гэрээг цуцлах	<p>18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.</p> <p>18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:</p> <ul style="list-style-type: none"> (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон; (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй; (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдан; (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй; (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон. <p>18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.</p>
19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр	<p>19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.</p> <p>19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.</p>
20. Гүйцэтгэлээс чөлөөлөх	<p>20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсоно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хэлсийг гүйцэтгэгчид төлнө.</p>

Найм. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <i>Нийтийн тээврийн зориулалтын зогсоол /ЧД, 6, 7, 8 дугаар хороо/ ажил ЧДХААА А19/043</i>
ГЕН 2.1	Ажил нь Нийтийн тээврийн зориулалтын зогсоол Ажлын талбай нь: /ЧД, 6, 7, 8 дугаар хороо/
ГЕН 2.1	Ажил эхлэх өдөр <i>Гэрээ байгуулах өдрөөс эхлэнэ</i> Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <i>Гэрээ байгуулсанаас хойш 30 хоног</i>
ГЕН 3.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 7.1	Чанарын баталгаат хугацаа 3 жил байна. Барьцаа хөрөнгө гэрээний үнийн дүнгийн 5 хувь байна.
ГЕН 9.1	Гэрээний хугацаанд засварын ажлыг хийж гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүн 0,05 хувиар тооцож алданги ногдуулна.
ГЕН 13.1	Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 10 % байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг 5 хоногийн дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ 200.000 /хоёр зуун мянган төгрөг/ байна.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)
(Албан тушаал)

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)
(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож оны ____ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж сууринуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай/_____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж сууринуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны _____ дугаар сарын ____-ны өдөр эхэлж, _____ оны _____ дугаар сарын ____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;

- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.
7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.
8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]